

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 04 сарын 08-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: . Инженерийн хийцтэй худаг
шинээр барьж байгуулах ажил
Тендер шалгаруулалтын дугаар: ДУГАОНӨГ/202102049

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Нэгдсэн үндэстний байгууллагын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангаас хамтран хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилт төсөл нь эрх бүхий тендерт оролцогчдоос Дундговь аймгийн сумдад нийт 10 инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.**

Санхүүгийн тайлан үзэх жилийн тоо: **Сүүлийн 2 жилийн буюу 2019, 2020 оны санхүүгийн жилийн эцсийн тайланг цахим системээс шалгана.**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил: **Ижил төстэй ажлын өртөг нь тендерт оролцогчийн санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Эрх бүхий байгууллагаас олгосон цооног өрөмдөх, тоноглох, усны барилга байгууламж барих, усны геофизикийн хайгуул, судалгааны ажил явуулах тусгай зөвшөөрөлтэй байх.**

Тендерийн үнийн дүнгийн 1 /нэг/ хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 09 цаг 30 минутанд нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Тендерийг хүлээн авах хаяг:

Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар, Нутгийн удирдлагын ордон
323 тоот Утас: 70593399